



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



СУУРЬ БОЛОВСРОЛЫН  
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ  
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

МОНГОЛ БИЧИГ

УЛААНБААТАР 2021





БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP



Japan International  
Cooperation Agency



ADB ASIAN  
DEVELOPMENT  
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

СУУРЬ БОЛОВСРОЛЫН  
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ  
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

# ЗӨВЛӨМЖ

МОНГОЛ БИЧИГ

*АНХНЫ ХЭВЛЭЛ*

УЛААНБААТАР 2021

Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмжийн анхны хэвлэл.  
(Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын үнэлгээний төв., УБ. 2021)

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

---

Суралцагчийн үнэлгээ.....	2
---------------------------	---

## СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

---

Нэг. Үндэсний бичгийн сургалтын хөтөлбөрийн онцлог ба үнэлгээ .....	5
Хоёр. Шалгуурт суурилсан үнэлгээ .....	9
Нэгж хичээл ба үнэлгээний нэгж.....	9
Суралцахуйн зорилт ба суралцахуйн үр дүн.....	11
Гурав. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар .....	21
Үнэлгээний даалгавар боловсруулах нь .....	21
Нэгж хичээлийн үнэлгээний даалгаврын жишээ.....	21
Дөрөв. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал.....	29

## СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго<sup>1</sup>/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх<sup>2</sup>/, үнэлж дүгнэх<sup>3</sup> зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-г суурилсан байна.

### ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

<sup>1</sup> Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

<sup>2</sup> Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

<sup>3</sup> Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад<sup>4</sup> нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



<sup>4</sup>Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.





## Нэг. Үндэсний бичгийн сургалтын хөтөлбөрийн онцлог ба үнэлгээ

Суурь, бүрэн дунд боловсролын үндэсний бичгийн сургалтын хөтөлбөрт нийт 64 зорилт тодорхойлсон байна.

Хүснэгт 1. Үндэсний бичиг хичээлийн суралцахуйн зорилтын тоо

Агуулгын ай	Хичээлийн нэр	БАГА БОЛОВСРОЛ					СУУРЬ БОЛОВСРОЛ					БДБ: ЗААВАЛ СУДЛАХ								
		I	II	III	IV	V	Нийт	VI	VII	VIII	IX	Нийт	X	XI	XII	Нийт	Нийт			
УНШИХ	Монгол хэл	13	8	9	10	11	51	8	5	7	5	25	7	7	4	18	94			
	Уран зохиол							7	7	7	7	28	7	7	7	21	49			
	Үндэсний бичиг											0	2	3	3	3	11	4	4	4
БИЧИХ	Монгол хэл	12	11	11	12	12	58	9	5	7	8	29	4	5	3	12	99			
	Уран зохиол							3	3	3	3	12	2	2	2	6	18			
	Үндэсний бичиг											0	5	5	4	3	17	3	3	2
ХЭЛ ЗҮЙ	Монгол хэл	7	4	4	4	4	23	4	3	3	1	11	4	5	3	12	46			
	Уран зохиол											0				0			0	0
	Үндэсний бичиг											0	1	3	3	1	8	5	3	
НСОХ-ЯР	Монгол хэл	5	4	4	4	4	21	2	2	2	2	8	2	1	2	5	34			
	Уран зохиол							2	2	2	2	8	1	1	2	4	12			
	Үндэсний бичиг															0				0
		37	27	28	30	31	153	43	38	41	35	157	39	38	29	106	416			

Үүнээс харахад 7-р ангид нийт 11 суралцахуйн зорилтын хүрээнд сурагчид үндэсний бичгийн мэдлэг чадвар эзэмшиж бичиг соёлоороо бахархах, сурч эзэмших, хөгжүүлэх хандлага төлөвшилтэй болно.

Үндэсний бичгийн сургалтын хөтөлбөр нь дараах онцлогтой: Үүнд:

1. Үндэсний бичигт эхлэн суралцах буюу үндсэн зурлага болон эгшиг, гийгүүлэгч үсгээ ялган таньж, үг, холбоо үг, өгүүлбэр, эхийг унших, цэвэр цэгцтэй бичиж сурах
2. Үндэсний бичгээр бичсэн эхийг зөв дуудан уншиж үг, өгүүлбэрийн утгыг ойлгох, эх орныхоо биет болон биет бус өв соёлоос суралцах, бахархах хандлагыг төлөвшүүлэх
3. Үндэсний бичгээр бичсэн эхийг шударга уншиж үг, өгүүлбэр, эхийн утгыг ойлгох, мэдээллийг үр дүнтэй хэрэглэх, уншсан зүйлээсээ суралцах, амьдралд хэрэгжүүлэх эрмэлзэлтэй болж төлөвших.
4. Үндэсний бичиг хичээл нь бичиг үсэгтэй суралцагчдад төрөлх бичиг үсгийг үндэсний соёл, зан заншил сэтгэлгээний онцлогтой эх дээр суурилан зааж сургах
5. Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилт нь бүхэллэг, нэгж хичээл бүрээр давтан хэрэгжихүйц байгааг анги бүрээр ахиулан хөгжүүлэх боломжтой томъёологдсон.

Доорх хүснэгтэд буй зорилтуудыг харвал анги бүрд үндэсний бичгээр унших чадварыг үсэг, үе холбон уншихаас эхлээд дармал, бичмэл, бийрийн гэх мэт янз бүрийн хэлбэрээр уншиж сурахаар тодорхойлсон байна. Энэ нь анги бүрийн төгсгөлд дармал бичмэл, бийрийн хэлбэрээр бичсэн эхийг сурагчид зайлшгүй уншиж сурсан байх тул нэгж хичээл бүрээр унших үйлийг хийж байхаар хичээлийн төлөвлөлт, зохион байгуулалтыг шаардаж байгаа юм.

Хүснэгт 2. Суурь боловсролын үндэсний бичгийн сургалтын хөтөлбөр дэх суралцахуйн зорилт –УНШИХ айн хүрээнд

VI ангид	VII ангид	VIII ангид	IX ангид
6.1а. Дуудлага бичлэг тохирдог үгийг шударга унших	7.1а. Дармал, бичмэл эхийг харьцуулж унших	8.1а. Дармал, бичмэл эхийг галигаар болон орчин цагийн дуудлагаар хослуулан унших аргаар эхийг шууд унших	9.1а. Дармал, бичмэл, бийрээр бичсэн эхийг хурдан, шударга уншиж ойлгох
6.1б. Дармал, бичмэл бүхий үг, холбоо үг, хялбар үгтэй өгүүлбэрийг унших	7.1б. Гадаад үг, өгүүлбэрийг шударга унших	8.1б. Үндэсний зан заншил, сэтгэлгээний онцлог бүхий эх, сургаалын зохиолыг шударга унших	9.1б. Уншсан эхээс түүхэн үг, хэллэгийн утгыг тольчлон тайлбарлах
	7.1в. Сурах бичгийн хүрээнд дуудлага бичлэг зөрүүтэй үгсийн хэлбэр, утгыг харьцуулан унших	8.1в. Бийрийн хичээнгүй бичгээс зөв унших	9.1в. Түүх, соёл, өв уламжлал бүхий монгол бичгийн хичээнгүй, дармал, хулсан үзэг, бийрийн хэлбэрээр бичсэн түүхэн зохиол судар бичгээс сонгон унших

6. Сурах бичгийн хувьд сургалтын хөтөлбөрийн агуулгыг нэгж хичээлээр хуваарилсан байдаг ба багш нар үүнийг үндэслэн сургалтын төлөвлөлтөө хийж хэвшжээ. Сурах бичигт буй нэгж хичээлийн агуулга нь унших, бичих, хэл зүйгээр суралцахуйн үйлээ тухайн нэгжид хамтад нь багтаасан байдаг. “Үндэсний бичиг VI” Ш.Чоймаа, Ө.Цэндсүрэн нар (Ёс заншил, уламжлалаа дээдэлье, Өв соёлоо эрхэмлэе, Эх орноо хайрлая, Монгол хүний эрхэм чанараас суралцъя, Өөрийгөө танья, Танин мэдэхүйн ертөнцөөр аялья. [https://econtent.edu.mn/book/7r\\_angi](https://econtent.edu.mn/book/7r_angi)) гэх мэт

Сургалтын хөтөлбөрийн онцлогийг мэдсэнээр үнэлгээний шалгуурыг үр дүнтэй хэрэгжүүлэх чадвартай болно. Хичээлд суурилсан, үр дүн, явцын үнэлгээгээр гэхчлэн аль ч түвшинд, ямар ч тохиолдолд энэхүү үнэлгээний шалгуураар үнэлэх боломжтой болно.

#### Багш та дараах асуултуудын хариултыг хаанаас олж болох вэ?


- Сурагчдаа үнэлсэн үнэлгээ, дүн миний ажилд ямар мэдээлэл өгөх вэ?
- Сурагчид маань, сурах мэдэх ёстой зүйлээ хэр зэрэг сурч байгаа вэ?
- Сурагчдаа сургалтын үйл ажиллагаанд хэрхэн татан оролцуулах вэ?
- Сурагчид хэр сурч байгаагаа мэдэж байгаа болов уу?
- Хэзээ хэрхэн, яаж тэднийг үнэлэх вэ?
- Үнэлгээний дүн хэр бодитой болов, дүн сайн/ муу бол би яах вэ?
- Сурагчдын даалгаврын гүйцэтгэлд ямар зөвлөмж өгвөл илүү үр дүнтэй вэ?

Энэ бүхний хариултыг үнэлгээнээс олох боломжтой. Учир нь үнэлгээ бол олон зорилготой.

- Үнэлгээ бол зүгээр нэг тест биш маш ч их зүйлийг агуулж байдаг.
- Бараг бүх үнэлгээ гүйцэтгэлд суурилсан байдаг.
- Үнэлгээ нь суралцахуй, багшлахуй, сургалтыг удирдан чиглүүлж байдаг.
- Үнэлгээ нь сурагчдын мэдлэг, чадварыг үнэлэхэд тохиромжтой бодит асуудлыг тусгасан байдаг.

- Үнэлгээ нь агуулга хэлбэр үйл явцтайгаа нийцсэн урьдчилан төлөвлөгдсөн байдаг.
- Үнэлгээ нь үндэслэлтэй, найдвартай, тохиромжтой, хэрэглэж болохуйц байх хэрэгтэй.
- Үнэлгээ нь хөндлөнгийн нөөлөлгүй, тогтвортой байх ёстой.
- Үнэлгээ ойлгомжтой, далд санаа агуулаагүй байх ёстой (Gallavan, Nancy P)

### ҮНЭЛГЭЭНИЙ ТӨРЛҮҮД



Энэчлэн үнэлгээний олон төрөл, арга хэлбэрийг бид олон жил ярьж хэрэгжүүлэхийг хичээсээр ирсэн хэдий ч төдийлөн үр дүнтэй арга замыг сонгож хараахан чадахгүй байгаа тал бий.

Багш суралцагчдынхаа тухай үнэлгээний мэдээллийг суралцахуйн бүхий л үйл явцад илүү өндөр үр дүнтэйгээр цуглуулж авах боломжийг эрж хайх үүднээс үнэлгээний шалгуурыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь чухал юм. Хичээлийн өмнө суралцагчдаа шинэ мэдлэг хүлээн авахад бэлэн байгаа эсэхийг тодорхойлсноор эндээс олж авсан чухал мэдээллээ хичээл төлөвлөхдөө ашиглах, хичээл зааж байхдаа суралцагчдынхаа ойлгож, хэрэглэж чадаж буй эсэхийг шалгаж, шаардлагатай тохиолдолд тэдэнд туслахын зэрэгцээ төлөвлөсөн аргууд нь аль хэр үр дүнтэй байгааг ажиглаж, хянаж, залруулах боломжтой юм.

Сургалтын, хичээлийн төгсгөлд суралцагчид суралцахуйн зорилтоо хэр биелүүлснээ шалгах боломж олгож ч болно. Энэ бүхний тулд багш ТА үнэлгээний шалгуурыг нээлттэй хэрэглэх нь илүү үр дүнтэй байх магадлалтай бөгөөд багш үнэлэхээс гадна сурагч өөрийгөө үнэлэх, бие биенээ үнэлэхдээ энэхүү шалгуурыг нээлттэй ашигласнаар хамтын үнэлгээний бодит, үнэн магадлалт байдал сайн болох билээ.

Юуны өмнө үнэлгээний шалгуур гэсэн нэрийн доор байгаа ойлголтуудыг сайн судалж үзвэл анги бүрээр сурч эзэмших мэдлэг чадвар тун тодорхой харагдахыг дараах байдлаар жишээлэн харуулж байна.

Хүснэгт 3. Суурь боловсролын үндэсний бичгийн сургалтын хөтөлбөрөөр анги бүрд эзэмшсэн байх суралцахуйн үр дүнг товчоолбол:

VI ангийн үндэсний бичиг хичээлийн суралцахуйн үр дүн	VII ангийн үндэсний бичиг хичээлийн суралцахуйн үр дүн	VIII ангийн үндэсний бичиг хичээлийн суралцахуйн үр дүн	IX ангийн үндэсний бичиг хичээлийн суралцахуйн үр дүн
Сурагч нь үндэсний бичиг үсэгт тайлагдаж, үндэсний бичгээр хялбар бичвэрийг уншиж ойлгох, хичээнгүй бичих, жинхэнэ нэр үгэнд дагавар, нөхцөл дагуулан бичих чадвар эзэмшиж, үндэсний бичиг үсэгт шамдан суралцах хүсэл эрмэлзэлтэй болно.	Сурагч үндэсний бичгийн дармал, бичмэл эхийг харьцуулан уншиж, хичээнгүй бичих, урт хос эгшиг, холбох эгшгийн дүрмийг мэдэж хэрэглэн, үйл үгийг хувилган бичих чадвар эзэмшинэ.	Сурагч дармал, бичмэл эхийг ойлгон шударга уншиж, хичээнгүй тигээр бичиж, , толь бичиг ашиглан, нэр, үйл үг бүтээх хувилгагч дагаврыг холбох ёсны дагуу зөв залган бичих чадвартай, үндэсний бичиг соёлоороо бахархах хүсэл эрмэлзэлтэй болно.	Сурагч нь эхийг агуулгыг ойлгон шударга уншиж, бийрийн бичмэл хэлбэрийг дуурайн, бичмэл ба дармал бийрийн эхийг хичээнгүй тигээр мөн дуудлага бичлэг зөрүүтэй үгс болон дагаврыг зөв залган бичиж, үндэсний бичиг үсэгт шамдан суралцах хүсэл эрмэлзэлтэй болно.

Хүснэгт 4. БДБ-ын үндэсний бичгийн сургалтын хөтөлбөрөөр анги бүрд эзэмшсэн байх суралцахуйн үр дүнг товчоолбол:

X ангийн үндэсний бичиг хичээлийн суралцахуйн үр дүн	XI ангийн үндэсний бичиг хичээлийн суралцахуйн үр дүн	XII ангийн үндэсний бичиг хичээлийн суралцахуйн үр дүн
Сурагч сурах бичигт байгаа ялгаатай тигээр бичсэн зохиол бүтээлийг уншиж, ойлгон түүхэн, хуучирсан үг хэллэгийн үгийн сан, хэл зүйн онцлог шинжийг тайлбарлаж үндэсний бичгийн толь хөтлөх, ашиглах арга барил эзэмшсэн идэвхтэй хэрэглээ бүхий үгсийг алдаагүй, зөв, хичээнгүй бичиж чаддаг болсон байна.	Сурагч монгол ёс заншил, уламжлалт мэдлэг ухаан, шинжлэх ухаан, танин мэдэхүйн эхийг уншиж ойлгон мэндлэх, хүндлэх, талархах, зөрүүлэх, цээрлэх, бэлгэдэх үг хэллэг, өргөн хэрэглээний өвөрмөц хэллэгтэй үг, идэвхтэй хэрэглээ бүхий үг хэллэгийн үндэс залгаврыг зөв бичдэг болно.	Сурагч монгол ахуй, хөдөлмөртэй холбоотой эх, бэлгэдэл, үсэг бичгийн сэдэвтэй эхийн үг хэллэгийг тайлбарлаж, гадаадын соёлтой жишиж ойлгодог болно.

## Хоёр. Шалгуурт суурилсан үнэлгээ

### НЭГЖ ХИЧЭЭЛ БА ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ

“Үндэсний бичиг хичээлийн сургалтын үр дүнг үнэлэх шалгуур” баримт бичигт үнэлгээний нэгж гэсэн нэршил байгаа. Бид үүнийг нэгж хичээлийн ойлголтоос ялгах хэрэг гарна.

Бидний мэдэх нэгж хичээл нь сургалтын хөтөлбөрийн агуулгыг томсгосон дидактик нэгжид хуваасан шийдэл бүхий агуулгын хуваарилалт юм. Энэ нэгж хичээлийг ойролцоогоор 5-10 орчим цагаар багцлан төлөвлөдөг ба хөтөлбөрийн унших, бичих, хэл зүйд байгаа суралцахуйн зорилтуудыг нэгж төдийгүй ээлжит хичээлд ч хамтад нь хэрэгжүүлдэг нь монгол хэл, үндэсний бичгийн хичээлийн онцлог юм. Харин үнэлгээний нэгж нь ямар агуулгын хүрээнд үнэлэхийг чиглүүлсэн сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтуудын багц юм.

### Нэгж хичээлийн тухай

ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөнд 6-9 дүгээр ангид үндэсний бичиг хичээлийг долоо хоногт тус бүр 2 цаг, жилд 66 нийт 264 цаг заахаар тусгасан<sup>1</sup>. Жишээ болгож 6-р ангийн нэгж хичээлийг харуулъя. (Багш нар өөр өөр хийх нь нээлттэй.)

*Нэгж хичээлийн сэдэв:*

#### VI анги

- |                               |   |
|-------------------------------|---|
| 1. Үндсэн зурлага, эгшиг үсэг | 5. Са, ша, за, жа, ца, ча гийгүүлэгч                  |
| 2. Титэмт гийгүүлэгч          | 6. Дэвсгэрлэх, үл дэвсгэрлэх үсэг, олон тооны дагавар |
| 3. Ра, Йа, Га, Ха гийгүүлэгч  | 7. Тийн ялгалын нөхцөлийг зөв дагуулан бичих          |
| 4. Ба, нг, да, та гийгүүлэгч  | 8. Хамаатуулах нөхцөлийг зөв дагуулан бичих           |

<sup>1</sup> Боловсрол, шинжлэх ухааны сайдын 491 дүгээр тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөө

Нэгж хичээлийн цагийг төлөвлөхдөө агуулгын багтаамж, сурагчдын сурах хурд, чадвар, туршлагыг харгалзан өөр өөр байдлаар тооцдог ба нэгж хичээлийн төгсгөлд үр дүнгийн үнэлгээ, ээлжит хичээлүүдэд явцын үнэлгээ хийдэг. Гэхдээ нэгжийн үнэлгээ нь улирал, хагас бүтэн жилийн үнэлгээний хувьд явцын үнэлгээ болдог.

### Үнэлгээний нэгжийн тухай

Үндэсний бичиг хичээлийн хувьд сургалтын хөтөлбөрийн агуулгын бүрэлдэхүүн хэсгийг баримжаалан “ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ”-ийг тодорхойлсон.

Хүснэгт 5. Суурь боловсролын үнэлгээний нэгж

	ҮI анги	ҮII анги	ҮIII анги	IX анги
Үнэлгээний нэгж 1.	Үндэсний бичгээр унших	Дармал, бичмэл эхийг унших	Үндэсний бичгээр унших	Үндэсний бичгээр унших
Үнэлгээний нэгж 2.	Үндэсний бичгээр бичих	Үндэсний бичгээр бичих	Үндэсний бичгээр бичих	Үндэсний бичгээр бичих
Үнэлгээний нэгж 3.	Хэл зүй (жинхэнэ нэрийн дагавар нөхцөлийг зөв бичих)	Хэлзүй	Хэлзүй	Хэлзүй

Тухайлбал, “Унших”, “Бичих”, “Хэл зүй” агуулгын айг тус тусад нь үнэлгээний нэг нэгж болгож холбогдох суралцахуйн зорилтуудыг тооцсон болно. Сурагчийн уншихтай холбоотой мэдлэг чадварыг, бичихтэй холбоотой мэдлэг чадварыг, хэл зүйтэй холбоотой мэдлэг чадварыг тус тус багтаасан үнэлгээ хийхэд баримжаалах нэгж юм.

Хүснэгт 6. 7-р ангийн үндэсний бичиг хичээлийн жишээ: Үнэлгээний нэгж ба суралцахуйн зорилт

Агуулгын ай	№	Үнэлгээний нэгж	Холбогдох суралцахуйн зорилтын код
Унших	1	Үндэсний бичгээр унших	7.1а, 7.1б, 7.1в
Бичих	2	Үндэсний бичгээр бичих	7.2а, 7.2б, 7.2в, 7.2г, 7.2д
Хэл зүй	3	Хэл зүй	7.3а, 7.3б, 7.3в

Ийнхүү үнэлгээний нэгжийг тогтоохдоо дараах зарчмыг баримталсан. Үүнд:

1. Сургалтын хөтөлбөрийн өөр өөр агуулгын айн суралцахуйн зорилтуудыг хооронд нь холихгүйгээр нэгж болгох, тухайлбал, унших агуулгыг бичих агуулгатай, эсвэл хэлний зүйн агуулгыг унших, бичихтэй холихгүй байхыг зорьсон.
2. Унших, бичих суурь чадвар нь нэг удаагийн, эсвэл нэг нэгж хичээлээр эзэмшдэг чадвар биш, ялангуяа үндэсний бичиг хичээлийн хувьд энэ нь илүү ялгарах тул олон удаа давтаж байж эзэмшдэгийг тооцож унших, бичих, хэл зүйн чадварыг үнэлэх нэгжийг тус тусад нь үнэлгээний нэгж болгосон. Эндээс үнэлгээний нэгж нь тухайн ангийн нэгж хичээлтэй тохирохгүй байгааг харж болно.

### Үнэлгээний нэгжийг хэрхэн хэрэглэх вэ?

“Үндэсний бичгээр унших”, “Үндэсний бичгээр бичих”, “Хэл зүй” гэсэн үнэлгээний 3 нэгж байгааг “Дэвсгэрлэх, үл дэвсгэрлэх үсэг” гэсэн нэгж хичээл дээр нэг удаа хэрэглэх биш “олон тооны дагавар”, “Тийн ялгалын нөхцөлийг зөв дагуулан бичих”, “Хамаатуулах нөхцөлийг зөв дагуулан бичих” гэх зэрэг нэгж хичээлүүдийн үнэлгээнд мөн л хэрэглэнэ гэсэн үг. Өөрөөр хэлбэл нэгж хичээл бүр дээр “унших”, “бичих” чадвараа, “хэл зүй”-н ойлголтыг нүдэлж тогтоох, зөв хэрэглэх чадвараа хамтад нь хөгжүүлж байдагтай холбоотой юм. Ингэхдээ “Хэл зүй” гэсэн үнэлгээний нэгжийн хувьд тухайн нэгж хичээлд байгаа хэл зүйн мэдлэг ойлголтоороо ялгагдана.

## СУРАЛЦАХУЙН ЗОРИЛТ БА СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

### Суралцахуйн зорилтын тухайд:

Суралцахуйн зорилт бол сурагчид үндэсний бичиг хичээлээр судалж эзэмших мэдлэг, чадварыг харуулдаг бөгөөд сургалтын хөтөлбөрт байгаа эдгээр зорилтын тоог *хүснэгт1*-ээр дээр харуулсан. Жишээ нь: 7-р ангийн үндэсний бичиг хичээлээр

- 7.1. УНШИХ** 7.1а. Дармал, бичмэл эхийг харьцуулж унших, 7.1б. Гадаад үг, өгүүлбэрийг шударга унших, 7.1в. Сурах бичгийн хүрээнд дуудлага, бичлэг зөрүүтэй үгсийн хэлбэр, утгыг харьцуулан унших
- 7.2. БИЧИХ** 7.2а. Бичмэл эхийг хичээнгүй хуулж бичих, 7.2б. Дармал эхийг бичмэлээр хичээнгүй хуулж бичих, 7.2в. Галиглан бичсэн өгүүлбэр, бичил эхийг үндэсний бичигт хөрвүүлэх, 7.2г. Урт, хос эгшигтэй үгийг зөв бичих, 7.2д. Үйл үгийн язгуур үндсийг цагаар төгсгөх нөхцөлөөр зөв ялган бичих
- 7.3. ХЭЛ ЗҮЙ** 7.3а. Урт, хос эгшигийг тэмдэглэх ёсыг таних, 7.3б Холбох эгшгийн дүрмийг таньж, цагаар төгсгөх нөхцөлөөр хувилган бичих, 7.3в. Холбох эгшгийн дүрмийг таньж үйл үгийг зөв хувилган бичих

### Суралцахуйн үр дүнгийн тухайд:


Суралцахуйн үр дүн нь тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчдын сурч эзэмших ёстой мэдлэг, ур чадварыг тодорхойлсон, тухайн мэдлэг, чадвар нь яагаад тэдэнд ашигтай болохыг ойлгоход нь туслах зорилготой. Сурагч юуг сурхан байхыг харуулна.

Суралцахуйн үр дүнг тодорхойлохдоо дараах хэдэн зүйлийг харгалзсан болно.

- Сургалтын хөтөлбөрийн агуулгаас хэд хэдэн суралцахуйн зорилтыг нэгтгэж ерөнхийлөн суралцахуйн нэг л үр дүн болгож тодорхойлсон. Жишээ нь энд 7-р ангийн сургалтын хөтөлбөрийн “Унших” агуулгын 3 суралцахуйн зорилтыг 2, Бичих агуулгын 5 суралцахуйн зорилтыг 1, хэл зүйн агуулгын 3 суралцахуйн зорилтыг 2; нийтдээ 11 суралцахуйн зорилтыг суралцахуйн 5 үр дүн болгосон байгаа.

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
7.2а. Бичмэл эхийг хичээнгүй хуулж бичих 7.2б. Дармал эхийг бичмэлээр хичээнгүй хуулж бичих 7.2в. Галиглан бичсэн өгүүлбэр, бичил эхийг үндэсний бичигт хөрвүүлэх 7.2г. Урт, хос эгшигтэй үгийг зөв бичих 7.2д. Үйл үгийн язгуур үндсийг цагаар төгсгөх нөхцөлөөр зөв ялган бичих	Дармал ба бичмэл эхийг хичээнгүй бичгээр хуулж бичиж чаддаг болно. Дармал ба бичмэл эхийг уншихдаа гадаад үг, өгүүлбэрийг зөв шударга уншиж чаддаг болно.

- Зарим тохиолдолд хэд хэдэн суралцахуйн зорилтыг нэгтгэхдээ тэдгээрийн хэрэгжих байдал, онцлогоос хамаарч 2-3 суралцахуйн үр дүн болгон тодорхойлсон. Тухайлбал 7.3б, 7.3в хоёр зорилт нь зөвхөн цагаар төгсгөх нөхцөлийг таних гэж ялгагдаж байгаа тул нэгтгэж нэг үр дүн болгосон. Гэтэл 7.3а зорилт нь холбох эгшгийн дүрэмд хамааралгүй “Урт, хос эгшигийг тэмдэглэх ёсыг таних” тул тус бүр нэг нэг үр дүн болгосон.



3. Суралцахуйн үр дүн нь сурах үйл явцыг бус, харин ямар үр дүнд хүрэх гэж хүсэж буйг хоёрдмол санаагүй, шууд ойлгогдохоор тодорхойлсон байна. Жишээ нь, “Дармал, бичмэл эхийг галигаар болон орчин цагийн дуудлагаар хослуулан унших аргаар эхийг шууд унших” гэвэл галиг, орчин цагийн дуудлага хоёроор хослуулан уншиж байгааг нь үнэлэх үү?, эсвэл шууд уншиж чадаж байгааг нь үнэлэх үү? гэсэн хоёрдмол ойлголт бий болгож байна.

Харин “Сурагч үндэсний бичгээр бичсэн эхийг шууд уншиж чаддаг болно.” гэвэл үндэсний бичгээр бичсэн эхийг түгдрэлгүй шууд уншдаг болох үр дүн нь тодорхой ойлгогдож байна.

Тиймээс л “ялган таньдаг болно”, “тодорхойлж чаддаг болно”, “тайлбарлаж чаддаг болно”, “зөв бичиж чаддаг болно”. “гэх мэтээр идэвхтэй, үр дүнг харуулах үйл үгээр төгсгөж, ирээдүй цагийн нөхцөлөөр хэлбэржүүлсэн. Мөн тухайн ангийн хөтөлбөрт байгаа идэвхтэй үйл үгийг нь харгалзан томъёолсон.

Дунд ангийн сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг хэрхэн нэгтгэж суралцахуйн үр дүн болгосныг дараах хүснэгтэд харууллаа. Эдгээрээс алийг нь нэгж хичээл бүрээр хэрэгжүүлэх, алийг нь тусгай нэг нэгж хичээлээр эзэмшүүлэхийг ойлгож авснаар зөв хэрэгжүүлэх юм.

Хүснэгт 7.

Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн	Хэрхэн хэрэгжүүлэх вэ?
<b>VI АНГИ</b>			
6.1a, 6.1б	Үндэсний бичгээр унших	Сурагч үндэсний бичгээр үзсэн үсгийн хүрээнд дармал болон бичмэл эхийг уншиж ойлгодог болсон байна.	Нэгж хичээл бүрээр хэрэгжинэ.
6.2a 6.2б 6.2в	Үндэсний бичгээр бичих	Сурагч танил үг, өгүүлбэрийг үндэсний бичгээр хичээнгүй, алдаагүй хуулж бичиж чаддаг болно.	Нэгж хичээл бүрээр хэрэгжинэ.
6.3a	Хэл зүй	Сурагч нэр үндэст олон тооны дагавар, тийн ялгал, хамаатуулах нөхцөлийг зөв дагуулан бичиж чаддаг болно.	Олон тооны дагавар, тийн ялгал, хамаатуулах нөхцөл гэсэн нэгж хичээлүүдээр хэрэгжинэ.
<b>VII АНГИ</b>			
7.1a 7.1б 7.1в	Үндэсний бичгээр унших	Сурагч дармал, бичмэл эхийг уншихдаа дуудлага бичлэг зөрүүтэй үгсийн хэлбэр, утгыг харьцуулан зөв шударга уншиж чаддаг болно. Сурагч дармал, бичмэл эхийг уншихдаа гадаад үг, өгүүлбэрийг зөв шударга уншиж чаддаг болно.	Нэгж хичээл бүрээр хэрэгжинэ.
7.2a 7.2б 7.2в 7.2г 7.2д	Үндэсний бичгээр бичих	Сурагч дармал, бичмэл эхийг хичээнгүй бичгээр хуулж бичиж чаддаг болно.	Нэгж хичээл бүрээр хэрэгжинэ.
7.3a 7.3б 7.3в	Хэл зүй	Сурагч урт, хос эгшгийн дүрмийг таньж чаддаг болно. Сурагч холбох эгшгийн дүрмийг таньж, үйл үгийг зөв хувилган бичиж чаддаг болно.	Урт, хос эгшиг, холбох ёс гэсэн нэгж хичээлүүдээр хэрэгжинэ.



VIII АНГИ			
8.1a 8.1б 8.1в	Үндэсний бичгээр унших	Сурагч үндэсний бичгээр бичсэн эхийг шударга уншиж чаддаг болно.	Нэгж хичээл бүрээр хэрэгжинэ.
8.2a 8.2б 8.2в 8.2г	Үндэсний бичгээр бичих	Сурагч үсгийн дармал, бичмэл тигээр хичээнгүй бичдэг болно.	Нэгж хичээл бүрээр хэрэгжинэ.
8.3a 8.3б 8.3в	Хэл зүй	Сурагч үндэсний бичгийн зөв бичих дүрмийг баримтлан алдаагүй зөв сайхан бичиж чаддаг болно.	Нэгж хичээл бүрээр хэрэгжинэ.
IX АНГИ			
9.1a 9.1б 9.1в	Үндэсний бичгээр унших	Сурагч эхийг шударга уншиж, агуулгыг ойлгож чаддаг болсон байна.	Нэгж хичээл бүрээр хэрэгжинэ.
9.2a 9.2б 9.2в	Үндэсний бичгээр бичих	Сурагч бичмэл хэлбэрийг дуурайж, хичээнгүй тигээр бичиж чаддаг болсон байна. Сурагч дуудлага бичлэг зөрүүтэй үгсийг зөв бичиж чаддаг болсон байна.	Нэгж хичээл бүрээр хэрэгжинэ.
9.3a	Хэл зүй	Сурагч дагаврыг зөв залган бичиж чаддаг болсон байна.	Нэр, үйл үг бүтээх дагаврууд гэсэн нэгж хичээлүүдээр хэрэгжинэ.

Үүнчлэн ахлах ангийнхыг багш нар өөрсдөө гаргаж үзсэнээр илүү сайн ойлгох юм.

Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн	Хэрхэн хэрэгжүүлэх вэ?
--------------------	-----------------	--------------------	------------------------

Суралцахуйн үр дүн гэдэг нь ижил ойролцоо чадвар олгох суралцахуйн зорилтууд буюу сурагчдын эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадварыг тодорхойлсон ойлголт.

Сургалтын хөтөлбөрт “*Үр дүнгийн үнэлгээ нь сурагчийн тухайн хичээлийн жил, хагас жил, бүлэг сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадварын түвшнийг тогтоох, хандлага төлөвшилд үнэлэлт, дүгнэлт өгөхөд чиглэнэ*” гэж зааснаар тухайн хүрээний эцсийн үнэлгээ болно. Ингэснээр хичээл сургалтынхаа үр дүнг тодорхойлохдоо олон хэсэг зүйлсээр эсвэл дутуудуулж зарим агуулга орхих зэргээс салж үнэлгээний нэг нэгжид байх 1-3 үр дүн жилийн 3 үнэлгээний нэгжийн 4-7 үр дүнд хүрсэн эсэхээр дүгнэж үзэх боломжтой болно. Үндэсний бичгийн хичээлээр бүрэн дунд боловсролын түвшинд хүрэх үр дүнг дараах байдлаар тодорхойлсон.

#### Х ангид

- Сурагч сурах бичигт байгаа ялгаатай тигээр бичсэн зохиол бүтээлийг уншиж, ойлгодог болно.
- Сурагч сурах бичиг дэх түүхэн, хуучирсан үгийн утгыг тайлбарлаж чаддаг болсон байна.
- Сурагч сурах бичгийн хүрээний идэвхтэй хэрэглээ бүхий үгсийг алдаагүй, зөв, хичээнгүй бичиж чаддаг болсон байна.
- Сурагч сурах бичгийн хүрээнд уншсан зохиол дахь түүхэн, хуучирсан үг хэллэгийн үгийн сан, хэл зүйн онцлог шинжийг тайлбарлаж чаддаг болсон байна.
- Сурагч үндэсний бичгийн толь хөтлөх, ашиглах арга барил эзэмшсэн байна.

**XI ангид**

- Монгол ёс заншил, уламжлалт мэдлэг ухаан, шинжлэх ухаан, танин мэдэхүйн эхийг уншиж ойлгодог болсон байна.
- Мэндлэх, хүндлэх, талархах, эерүүлэх, цээрлэх, бэлгэдэх үг хэллэг, өргөн хэрэглээний өвөрмөц хэллэгтэй үг, идэвхтэй хэрэглээ бүхий үг хэллэгийн үндэс залгаврыг зөв бичдэг болсон байна. ГМ

**XII ангид**

- Үсэг бичиг, монгол бэлгэдлийн сэдэвт эхийн үг хэллэгийг тайлбарладаг болсон байна.
- Монгол бэлгэдлийг бусад орны өв соёлтой жишиж ойлгодог болсон байна.
- Сурах бичгийн хүрээний гадаадын уран зохиолын гадаад үгийг үндэсний бичгээр зөв бичдэг болсон байна.
- Монгол ахуй, хөдөлмөртэй холбоотой эхийг дэлгэрүүлж, хураангуйлж бичдэг болсон байна.

**Үнэлгээний шалгуур ба гүйцэтгэлийн түвшин**

Үнэлгээний шалгуур нь стандартын шаардлагыг хангаж, сургалтын үр дүнд хүрсэн байдлыг харуулахын тулд цуглуулах нотолгоог хэлнэ. Үнэлгээний шалгуур нь хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй (*Sadler, 1987*). Үүнд:

1. Шалгуур (criterion). Шалгуур нь “Би юу хийх ёстой вэ?” гэдэг асуултад хариулна.
2. Гүйцэтгэлийн түвшин (Achievement Standard, Performance Standard) “Би яаж хийх ёстой вэ?” гэдэгт хариулна.

***Шалгуур (criterion)***

Үнэлгээний шалгуур нь суралцахуйн үр дүнд хүрснийг харуулахын тулд сурагчид юу хийх ёстойг ойлгомжтой болгохоос гадна багш нарт сурагчдын амжилт, гүйцэтгэлийн талаар дүгнэлт хийх хүчин зүйлсийг тодорхойлно. Өөрөөр хэлбэл үнэлгээний шалгуур нь сурагчдад хүрсэн үр дүн, амжилтыг харуулахын тулд юу хийх ёстойг нь тодорхой харуулдаг бол багш нарын хувьд сурагчдын гүйцэтгэлийн талаар дүгнэлт хийхдээ харгалзан үзэх хүчин зүйлүүдийг харуулдаг. Сургалтын эхэнд үнэлгээний шалгуурыг сурагчдад танилцуулах нь тэдний сурах итгэлийг нэмэгдүүлж, гүйцэтгэлийг сайжруулахад туслах үр дүнтэй арга юм. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тодорхой зааж өгөх нь сургалтын хөтөлбөрт юу чухал, юу үнэ цэнтэй болохыг таньж мэдэхэд, сургалтын гол үр дүнд хүчин чармайлтаа төвлөрүүлж, өөрийгөө үнэлэх, эргэцүүлэн бодох замаар өөрсдийн гүйцэтгэлийг үнэлэхэд нь тусалдаг. Үнэлгээний шалгуур нь сургалтын явцыг дэмжихэд чиглэсэн сургалтын санал хүсэлт өгөх, түүнчлэн улирлын төгсгөлийн нэгтгэн дүгнэх арга юм.<sup>2</sup>

Үнэлгээг зөв хийснээр багш суралцагчдын хоорондох мэдээлэл болон харилцаа ойлголцол сайжирч илүү баялаг, илүү үр дүнтэй болохын зэрэгцээ хичээл сургалтын үйл ажиллагаа нь оновчтой болж суралцахуй жинхэнэ утгаараа хэрэгжиж суралцагчийн мэдлэг чадвар бодитоор өөрчлөгдөнө.

Сурагч суралцахуйн үр дүнд хүрч байгаа эсэхийг тодорхой шалгуураар үнэлнэ.

<sup>2</sup> <https://ctet.royalroads.ca/writing-effective-assessment-criteria/>

## 8-р ангийн үнэлгээний нэгж 1. ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР УНШИХ


Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
8.1.а Дармал, бичмэл эхийг галигаар болон орчин цагийн дуудлагаар хослуулан унших аргаар эхийг шууд унших	Сурагч үндэсний бичгээр бичсэн эхийг <b>шууд, зөв</b> уншиж чаддаг болно.
8.1.б Үндэсний зан заншил, сэтгэлгээний онцлог бүхий эх, сургаалын зохиолыг шударга унших	
8.1.в Бийрийн хичээнгүй бичгээс зөв унших	

Үнэлгээний нэгж тус бүрээр сурагчийн хүрэх суралцахуйн үр дүнгийн шалгуур

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
	Сурагч үндэсний бичгээр бичсэн эхийг <b>шууд, зөв</b> уншдаг болно.	Дармал, бичмэл, бийрийн эхийг <b>шууд, зөв</b> уншдаг.

Үнэлгээний шалгуур нь суралцахуйн үр дүнгээс ялгаатай.

- Суралцахуйн үр дүн нь сурагчийн юу сурсан байхыг харуулдаг бол үнэлгээний шалгуур нь сурагч сурсан эсэхээ яаж мэдэх вэ гэдгийг харуулна.



- Сурагч **юуг** сурсан байх вэ?
- Сурсан эсэхийг **хэрхэн** мэдэх вэ?

#### Үнэлгээний шалгуур нь:


- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн яаж, юугаар тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл.

Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой. Шалгуур нь суралцагчийн хүрсэн үр дүн буюу амжилтыг нотлон харуулахад чиглэнэ.

Үнэлгээний шалгуур томъёолоход идэвхтэй үйл үг хэрэглэх, ялангуяа суралцахуйн үр дүнг томъёолоход хэрэглэсэн үйл үгтэй тохирч байх, мөн суралцахуйн үр дүнгийн танин мэдэхүйн түвшинтэй тохирч байх, суралцахуйн үр дүнг илүү тодорхой болгох, хэрхэн яаж үнэлэхийг харуулна.

#### Гүйцэтгэлийн үзүүлэлт ба түвшин

Гүйцэтгэлийн үзүүлэлт бол чанарын тодорхой түвшин (амжилт эсвэл гүйцэтгэл)-ий тухай ойлголт юм. Суралцахуйн үр дүнг үнэлэх шалгуур нь суралцахуйн үр дүнд хүрсэн үү? Юу хийж чаддаг болсон бол үр дүнд хүрсэн гэх вэ? гэсэн асуултад хариулагдах бол гүйцэтгэлийн үзүүлэлт нь “Би яаж хийх ёстой вэ?” гэдэгт хариулна.



- Сурсан эсэхийг **хэрхэн** мэдэх вэ?
- Юу **хийж чаддаг бол үр дүнд хүрсэн** гэх вэ?
- Би **яаж хийх** ёстой вэ?

Үнэлгээний шалгуурын гүйцэтгэлийн түвшнийг тодорхойлоход анхаарах зүйл:

- Үнэлгээний шалгуурыг ямар түвшинд хангаж байна вэ? Үнэлгээний шалгуур болон гүйцэтгэлийн танин мэдэхүйн нэг түвшинд байх
- Гүйцэтгэлийн түвшин бүрд гүйцэтгэх үйл харилцан адилгүй, түвшин нь ялгаатай байж болохгүй зэргийг баримтлан тогтоосон болно.

7-р ангийн “Үндэсний бичгээр унших” нэгж буюу унших агуулгын хүрээнд сурагчдын эзэмших “Дармал ба бичмэл эхийг уншихдаа дуудлага бичлэг зөрүүтэй үгсийн хэлбэр, утгыг харьцуулан зөв шударга уншиж чаддаг болно.” гэсэн суралцахуйн үр дүнг үнэлэх шалгуур, тэдгээрийн гүйцэтгэлийн түвшнийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 8.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИН			
	I	II	III	IV
Сурагч дармал ба бичмэл эхийг уншиж, чадна.	Бичмэл эхийг үелж уншиж чаддаг.	Бичмэл эхийг уншиж чаддаг.	Дармал, бичмэл эхийн ихэнхийг уншиж чаддаг.	Дармал, бичмэл эхийг уншиж чаддаг.
Сурагч гадаад үгийг уншиж чадна.	Гадаад үг, өгүүлбэрийг унших гэж оролддог.	Гадаад үг, өгүүлбэрийн заримыг нь уншиж чаддаг.	Гадаад үг, өгүүлбэрийг хам орчноос нь уншиж чаддаг.	Гадаад үг, өгүүлбэрийг шударга зөв уншиж чаддаг.

Урьдчилсан үнэлгээ, явцын болон үр дүнгийн үнэлгээ гэсэн бүх төрлийн үнэлгээ нь суралцахуйн үйл явцыг өөр өөрсдийн онцлог аргаар хүчтэй дэмждэг. Багш та эдгээр үнэлгээ бүрийг өндөр түвшинд эзэмшсэнээр суралцагчдынхаа суралцахуйг сайжруулах чадвар нь сайжирч багшлах ажилдаа илүү урам зоригтой болно.

Багш бүрийн эзэмших үр чадваруудад хичээлд суурилсан үнэлгээний аргачлал, системийг бүрэн эзэмшсэн байх чадвар багтах ёстой.

Үнэлгээ бол үр дүнтэй багшлахуйн нэг чухал хэсэг байсаар ирсэн бөгөөд өнөөгийн суралцагчдын онцлогийг харгалзах олон талын хэрэгцээ шаардлагыг хангах, 21-р зууны багшлахуйн хэмжүүр өндөр болж байгаа зэрэгтэй уялдаж ач холбогдол нь улам бүр чухал болж байна.

**Үнэлгээний шалгуурыг жилийн, нэгжийн, ээлжит хичээлийн хувьд хэрхэн ашиглаж болох вэ?**

1. **Оношлох үнэлгээ:** Сургалт эхлэхийн өмнө сурагчдын эзэмшсэн суурь мэдлэг, чадварын түвшнийг тодорхойлох хэрэгтэй болдог. Өөрөөр хэлбэл сурагчдын суралцахуйд ямар ямар бэрхшээл гарч буйг илрүүлж, тэдгээрийн шалтгааныг олоход чиглэдэг.

3.5.Оношлох үнэлгээ нь хичээлийн жилийн эхэнд эсвэл нэгж хичээл, бүлэг сэдэв эхлэхийн өмнө суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг тандах зорилгоор хийх үнэлгээ байна. Оношлох үнэлгээг ажиглалт, ярилцлага, хэлэлцүүлэг, асуулт, сорил, судалгаа гэх мэт хэлбэрээр хийнэ.

*Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/425 дугаар тушаалын хавсралт*

Оношлох үнэлгээний мэдээлэл нь суралцахуйн тодорхой зорилтыг биелүүлэхэд болон суралцагчдын тодорхой нэг бүлэгт багшлахуйн загвар, арга зүй хэр нийцтэй байх талаар багшид мэдээлэл өгдөг.

2. **Үр дүнгийн үнэлгээ:** Энэ үнэлгээ нь хичээлийн агуулгыг сурагчид хэр эзэмшсэн, тухайлбал тэдний эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд үнэлгээ өгөх зорилгоор хэрэглэгддэг.

Үр дүнгийн үнэлгээний зохистой хэрэглээ нь багшлах ур чадвараа өндөр түвшинд байлгахыг хүсэж буй багш нарын зайлшгүй хэрэглэх ёстой хэрэглүүр. Үр дүнгийн үнэлгээнээс авсан мэдээлэл багшид

- суралцагчид юу сурсан
- заах арга нь суралцахуйд хэрхэн нөлөөлж байгаа
- суралцахуйд нөлөөлсөн бол чухам яаж гэх зэрэг илүү тодорхой ойлголттой болоход нь тусална.

3.8. Үр дүнгийн үнэлгээг сурлагын амжилтын үр дүнг хэмжих зорилгоор бүлэг сэдвийн төгсгөл болон хагас жил /II улирлын төгсгөл/, хичээлийн жилийн эцэс /IV улирлын төгсгөл/-т хийнэ. Анги дэвших, улсын шалгалт нь үр дүнгийн үнэлгээ байна.

3.9. Үр дүнгийн үнэлгээг аман болон бичгийн шалгалт, сорил, туршилт, судалгааны ажил, тайлан, төсөлт ажил, илтгэл, эссэ, бүтээл, биечлэн хийж гүйцэтгэх зэрэг хэлбэрээр хийнэ.

*Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/425 дугаар тушаалын хавсралт*

Жилийн эцсийн шалгалтын даалгавар боловсруулахдаа тухайн ангид сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг үнэлдэг тул энэхүү шалгуурыг бүхэлд нь ашиглаж болно.

Нэгж хичээлийн явцад сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэхдээ эдгээр шалгуурыг хэсэгчлэн ашиглаж болно. Нэгж хичээлийн дараах үнэлгээг жилийн эцсийн үр дүнгийн үнэлгээтэй харьцуулбал явцын үнэлгээ, харин ээлжит хичээлийн үнэлгээтэй харьцуулбал үр дүнгийн үнэлгээ болно. Өөрөөр хэлбэл, агуулгын нэг нэгж буюу нэгж хичээлээр 8 орчим цагт эзэмшсэн мэдлэг чадвараа үнэлүүлж байгаа хэрэг болно.

**3. Явцын үнэлгээ:** Энэ үнэлгээг хичээл, сургалтын явцад хэрэглэх бөгөөд сурагчийн суралцах үйл хэрхэн явагдаж байгаа талаар мэдээлэл авч, багшлах үйлд тохируулга хийх, сурагчийн хэрэгцээнд нийцсэн хариу мэдээлэл-зөвлөгөө өгөх, багш сурагчийн хамтран хэрэгжүүлэх үйл явц болно.

3.6. Явцын үнэлгээ нь суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл, сургалтын явцад тогтмол хийх үнэлгээ байна.

3.7. Явцын үнэлгээг хичээлийн явцад суралцагчийн суралцах үйлийг дэмжихэд чиглэсэн ажиглалт, асуулт, ярилцлага, хэлэлцүүлэг, бие даах ажил, рубрик, суралцагчийн өөрийн болон бусад суралцагчийн үнэлгээ гэх мэт арга, хэлбэрээр багш хийнэ. Явцын үнэлгээг сургалтын баримт бичиг / багшийн журнал/-т стандарт бус тэмдэглэгээгээр тэмдэглэж болно.

*Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/425 дугаар тушаалын хавсралт*

Явцын үнэлгээгээр сурагчдын суралцахуйтай холбоотой мэдээлэл цуглуулж болох бөгөөд хариу мэдээлэл өгөх олон арга хэрэгслийг судлаачид санал болгосон байдаг. Жишээ нь: Явцын үнэлгээний үр дүнд сурагч “Би юу мэддэг, юу чаддаг вэ?”, “Цаашид бие дааж эсвэл багшийн дэмжлэгтэйгээр юу сурах вэ, илүү сайн сурахын тул яах ёстой вэ? гэдгээ ойлгоход туслах болно.

Явцын үнэлгээг хэрэгжүүлснээр хичээлийн явцад суралцагчдын суралцахуйг багшийн заах аргын ямар загвар, аргачлал, үйл ажиллагаа, даалгавар нь илүүтэй дэмжиж байгааг эсвэл дэмжихгүй байгааг ч шалгаж болдог.

Аливаа үнэлгээ нь багш сурагчийг, сурагч өөрийгөө, эсвэл бусдыг үнэлэхэд болон багшлах, суралцах үйл ажиллагааг сайжруулахад нэмэр болохуйц хариу мэдээлэл (feedback)-ээр хангаж байвал суралцахуйд тус болно. Ийм үнэлгээний хувьд сурагчийн сурах хэрэгцээнд багшлах үйл ажиллагааг тохируулахад үнэлгээний баримт, нотолгоонууд ашиглагдаж байгаа тохиолдолд тэр нь явцын үнэлгээ болно<sup>3</sup>.

Харин ээлжит хичээлийн тухайд явцын үнэлгээг голлох бөгөөд шалгуурт баримжаалсан болон гүйцэтгэлд суурилсан үнэлгээг ашиглаж болно.

Гүйцэтгэлд суурилсан үнэлгээ нь сурагчдын оролцоог нэмэгдүүлсэн, оюун ухааныг сорьсон, гарсан үр дүнг урамшуулсан байдлаар төлөвлөх боломж олгодог.

<sup>3</sup> Black, Harrison, Lee, Marshall, William; ‘Working Inside the Black Box’, 2004

Сургалтын явцад сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг үнэлэхэд рубрикийн хүснэгтээр шинжилж, үнэлж болно. Рубрикийг багш ашиглахаас гадна сурагчдад өгч өөрийнх нь гүйцэтгэлд, эсвэл бусад сурагчийн гүйцэтгэлд үнэлгээ өгүүлж болно. Сурагчдаар үнэлгээ хийлгэх рубрикийн хуудсанд оноо өгөх шаардлагагүй.

Рубрик нь сурагчийн гүйцэтгэлийн янз бүрийн түвшнийг үнэлэхэд ашигладаг багц хэрэглэгдэхүүний нэг. Рубрикийг шалгуурт баримжаалан боловсруулдаг. Шалгуур нь сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй тохирч байхаар, гүйцэтгэлийн түвшин бүр нь сурагч ойлгохоор энгийн хэлээр бичигдсэн, товч, хэмжигдэхүйц байхаар төлөвлөгдсөн байна. Рубрикийг хүснэгтээр илэрхийлдэг.

Хүснэгтийн босоо баганад гүйцэтгэлийн түвшнийг, хөндлөн мөрөнд шалгуурыг бичнэ. Гүйцэтгэлийн түвшнийг зүүнээс эхлэн баруун тийш бууруулан эрэмбэлж байрлуулсан нь нийтлэг байдаг. Жишээ нь: 3x3x3 загвар

Шалгуур	Гүйцэтгэлийн түвшин		
	Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй
Шалгуур 1			
Шалгуур 2			
Шалгуур 3			

**Рубрикийг яагаад хэрэглэдэг вэ?**

- ✓ Үнэлгээ хийх шалгуур, түвшин тодорхой болсон байдаг. Тухайн даалгавраас хамаарч ямар шалгуураар оношилж болохыг тодорхойлно. Ийнхүү сурагчдын мэдлэг, чадварын түвшнийг тодорхойлох үзүүлэлтийг урьдчилан тодорхойлох нь багшийн цагийг хэмнэх төдийгүй үнэлгээг бодитой болгоход тусална.
- ✓ Сурагчдад өөрийн гүйцэтгэлийг бодитой үнэлэх боломж бүрдэнэ. Гүйцэтгэлээ рубрик ашиглан түвшин, шалгуурын дагуу тэмдэглэх нь богино хугацаанд бодитой үнэлгээ хийхэд тусална.
- ✓ Гаргасан үндэслэлээ тайлбарлах боломжтой. Рубрик ашигласнаар багш, сурагчид даалгаврыг хэрхэн гүйцэтгэх, тухайн даалгаврыг гүйцэтгэснээр сурагчид ямар мэдлэг, чадвар эзэмших нь ил тод болно.
- ✓ Сурагчийн идэвх оролцоог нэмэгдүүлдэг. Үнэлгээ ил тод байх нь сурагчдад сурах хүсэл тэмүүллийг төрүүлнэ.

**Рубрикийг хэрхэн боловсруулах вэ?**

- ✓ Даалгаврын зорилгыг тодорхойлох; (Ямар мэдлэг, чадвар, үнэт зүйлийг үнэлэх гэж байна вэ?)
- ✓ Шалгуур, үзүүлэлтүүдийг тодорхойлох;
- ✓ Гүйцэтгэлийг түвшинчилэх; (4 байвал сайн)
- ✓ Түвшин хоорондын ялгааг сайн тодорхойлох;
- ✓ Гүйцэтгэлийн түвшинд харгалзах оноог өгөх гэх зэргээр рубрикийг монгол хэлний хичээлд ашиглах боломжтой.

7-р ангид сурагчдын үндэсний бичгээр бичих чадварыг үнэлэх рубрикийн жишээ:

Шалгуур	Хангалтгүй I	Дунд зэрэг II	Сайн III	Маш сайн IV
Сурагч дармал болон бичмэл эхийг уншиж, чадна.	Бичмэл эхийг үелж уншиж чаддаг.	Бичмэл эхийг уншиж чаддаг.	Дармал, бичмэл эхийн ихэнхийг уншиж чаддаг.	Дармал, бичмэл эхийг уншиж чаддаг.
Сурагч гадаад үгийг уншиж чадна.	Гадаад үг, өгүүлбэрийг унших гэж оролддог.	Гадаад үг, өгүүлбэрийн заримыг нь уншиж чаддаг.	Гадаад үг, өгүүлбэрийг хам орчноос нь уншиж чаддаг.	Гадаад үг, өгүүлбэрийг шударга уншиж чаддаг.
Сурагч дармал болон бичмэл эхийг хичээнгүй бичиж чадна.	Сурагч бичмэл эхээс үелж хуулж бичиж чаддаг.	Сурагч бичмэл эхээс хичээнгүй хуулж бичиж чаддаг.	Сурагч дармал эхээс бичмэлээр хуулж бичиж чаддаг.	Сурагч дармал болон бичмэл эхийг хичээнгүй хуулж бичиж чаддаг.
Сурагч дармал болон бичмэл эхээс урт, хос эгшигтэй үг ба цагаар төгсгөх нөхцөлтэй үйл үгсийг ялган хичээнгүй бичиж чадна.	Сурагч бичмэл эхээс урт, хос эгшигтэй үгийг ялган бичиж чаддаг.	Сурагч дармал болон бичмэл эхээс урт, хос эгшигтэй үгийг ялган бичиж чаддаг.	Сурагч дармал болон бичмэл эхээс урт, хос эгшигтэй үг ба цагаар төгсгөх нөхцөлтэй үйл үгсийг ялган бичиж чаддаг.	Сурагч дармал болон бичмэл эхээс урт, хос эгшигтэй үг ба цагаар төгсгөх нөхцөлтэй үйл үгсийг ялган хичээнгүй бичиж чаддаг.
Сурагч дармал болон бичмэл эхийг харьцуулан уншиж бичихдээ урт, хос эгшгийн дүрмийг таньж чадна.	Эх, өгүүлбэрээс урт, хос эгшигтэй үгийг ялган таньдаг.	Уртатгалыг тэмдэглэх аргуудыг ашиглан хялбар үгсийг зөв бичдэг.	Хос эгшигтэй үгийг зөв бичдэг.	Урт, хос эгшгийг тэмдэглэх ёсны дагуу урт, хос эгшигтэй үгийг зөв бичдэг.
Сурагч дармал болон бичмэл эхийг харьцуулан уншиж бичихдээ холбох эгшгийн дүрмийг таньж, үйл үгийг зөв хувилган бичиж чадна.	Эхээс цагаар төгсгөх нөхцөлтэй зарим үгийг таньж бичдэг.	Эхээс цагаар төгсгөх нөхцөлтэй үгийг таньж бичдэг.	Сурах бичгийн хүрэн дэх эхээс холбох эгшгийн дүрмийг таньж, цагаар төгсгөх нөхцөлөөр зөв хувилган бичдэг.	Сурах бичгийн хүрэн дэх эхээс нөхцөлдүүлэн холбох нөхцөлийг ялган таньж, холбох эгшгийн дүрмээр зөв бичдэг.

Ахлах ангид үндэсний бичгийн хичээл ордог багш жилийн төлөвлөлтийг сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжид үндэслэн хийнэ. Агуулгын багтаамжаас шалтгаалаад суралцахуйн зорилтуудаа оновчтой хуваарилан нэгж хичээл болгох бол түүнийг дагуулан үнэлгээний шалгуур сонгон авна. Жишээ нь: Х дугаар ангийн нэгж хичээлүүдээ дараах байдлаар хувааж шалгууруудаас тохируулан сонгож хэрэглэх юм.

Хүснэгт 9. X ангийн жишээгээр харуулбал:

№	Суралцахуйн зорилт	Нэгж хичээлийн агуулга	Үнэлгээний шалгуур						
			Сурах бичиг дэх дармал, бичмэл, хорголжин бар, хулсан үзгийн тигээр бичсэн бичвэрийг уншиж ойлгодог	Зохиолоос түүхэн болон хуучирсан үг хэллэгийг олж, утгыг нь тайлбарладаг.	Сурах бичгийн хүрээнд уншсан зохиолын үгийн санг судалж онцлогийг нь тайлбарладаг.	Уншсан зохиолд байгаа түүхэн ба орчин цагийн бүтээврүүдийн хэл зүйн онцлогийг тайлбарладаг	Сургаалын зохиолын үгсийг бүлэглэх, ангилах, төрөлжүүлэх аргаар судалж, түүхэн болон хуучирсан үг хэллэгээр тайлбар толь хөтөлдөг	Кириллээс үндэсний бичигт хөрвүүлж хичээнгүй тигээр цэвэр нямбай бичдэг.	Сурах бичгийн хүрээний идэвхтэй хэрэглээ бүхий үгийн үндэс залгаврыг холбох эгшгийн дүрмээр зөв бичдэг
1	10.1а, 1б, 1в, 2а, 3а, 3б	Сонгодог бичгийн зохиол 1	+	+	+	+		+	
2	10.1а, 1б, 1в, 2а, 3в, 3д	Сонгодог бичгийн зохиол 2	+	+	+		+	+	
3	10.1а, 1г, 2б, 2в, 3г	Монголын орчин үеийн өгүүллэг	+				+	+	+
4	10.1а, 1г, 2б, 2в, 3г	Монголын орчин үеийн яруу найраг	+				+	+	+



## Гурав. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар

### Үнэлгээний даалгавар боловсруулах нь

7 дугаар ангийн үндэсний бичгийн хичээл нь 8 нэгж хичээл тус бүрээр үр дүнгийн үнэлгээ хийх бөгөөд үнэлгээний даалгавар нь сурагчдын эзэмшсэн унших чадвар, бичих чадвар, хэлний зүйн мэдлэг, ойлголт, хэрэглээ гэсэн хүрээнд даалгавар боловсруулна. Гэхдээ тухайн нэгж хичээлийн агуулгаас хамаарч зарим нэгж хичээлийн үнэлгээний даалгавар нь энэ гурван агуулгыг бүхэлд нь хамардаг бол зарим тохиолдолд өөр байж болно. Өөрөөр хэлбэл нэгж хичээлийн үнэлгээ нь тухайн нэгж хичээлийн зорилго агуулгад нийцэж байх шаардлагатай гэсэн үг.

### Нэгж хичээлийн үнэлгээний даалгаврын жишээ:

Уншиж ойлгосныг амаар болон бичгээр шалгаж болно. Асуултад хариулах, хэлний зүйн мэдлэг ойлголтыг сонгох хариулттай тест, зохион бичих чадварыг задгай хариулттай даалгаврууд байж болно. Унших чадварыг үнэлгээний “Эхийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх” нэгжийн багц шалгуураар үнэлнэ.

#### **НЭГ. УНШИХ ЧАДВАР:**

Сурагчид унших гэж юу болохыг мэддэг ч унших үр чадвараа яаж ахиулах аргаа сайн мэддэггүй. Гэтэл багш нар сурагчдаа их зүйл уншихыг шаарддаг ч үр дүн төдийлэн сайн байдаггүй. Сурагчдын нас сэтгэхүй, хэрэгцээнд тохирсон эхийг сонгон уншуулах явдал чухал. Уншихдаа аль болох бага хугацаанд дэлгэрэнгүй мэдээлэл авах, уншсанаа эргэцүүлэн тунгааж ойлгодог, өөрт хэрэгтэй зүйлийг олж авдаг байх нь чухал.

Даалгаврын зорилго: Үндэсний бичгийн дармал эхийг уншиж ойлгох

“Өглөө бүр дэлбээгээ нээж, орой бүр хумьдаг бөлбөө цэцэг” эхийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

Хөвсгөл аймгийн байгалийн сайхны тухай  
Цэцэгт нуурын тухай  
Байгалийн сонин үзэгдлийн тухай  
Аялалын сонин сайхны тухай

Цагаан, ягаан цэцэгс хаана ургадаг вэ?  
А. Сумын төвөөс хойш  
Б. Том ногоон навчин дээр  
В. Нуурын эрэгт усан дээр  
Г. Гүехэн усны ёроолоос

Цэцэгс хэзээ дэлбээгээ нээж, хэзээ хумьдаг вэ?  
А. Нар мандахад нээж, өглөө хумих  
Б. Үзүүр уснаас ил гарахад нээх  
В. Өглөө нээж, орой хумих  
Г. Орой нээж, өглөө хумих

Эхэд гадаад үгэнд орох үсэгтэй үг болоод үгийн товчлол хэд байна вэ? Ямар ямар үгс вэ?  
А.2                      Б.3                      В.4                      Г.5

.....

Ягаан, цагаан цэцэгс үзэсгэлэнтэй байгаагийн нууцыг юу гэж бодож байна?  
А. Том далбагар навч дэвсэж өнгийн цэцэг тавьсан юм шиг харагддаг  
Б. Нуурын эрэг орчмын гүехэн усанд ургадаг учраас  
В. Тодорхой хугацаанд дэлбээгээ нээж, хумьдаг болохоор  
Г. Байгаль дэлхийн өвөрмөц сонин бүтээл

**Гүйцэтгэх даалгавар:**

1. Эхэд юуны тухай өгүүлсэн бэ?  
А. Хөвсгөл аймгийн байгалийн сайхны тухай  
Б. Цэцэгт нуурын тухай  
В. Байгалийн сонин үзэгдлийн тухай  
Г. Аялалын сонин сайхны тухай
2. Цагаан, ягаан цэцэгс хаана ургадаг вэ?  
А. Сумын төвөөс хойш  
Б. Том ногоон навчин дээр  
В. Нуурын эрэгт усан дээр  
Г. Гүехэн усны ёроолоос
3. Цэцэгс хэзээ дэлбээгээ нээж, хэзээ хумьдаг вэ?  
А. Нар мандахад нээж, өглөө хумих  
Б. Үзүүр уснаас ил гарахад нээх  
В. Өглөө нээж, орой хумих  
Г. Орой нээж, өглөө хумих
4. Эхэд гадаад үгэнд орох үсэгтэй үг болоод үгийн товчлол хэд байна вэ? Ямар ямар үгс вэ?  
А.2                      Б.3                      В.4                      Г.5
- .....
5. Ягаан, цагаан цэцэгс үзэсгэлэнтэй байгаагийн нууцыг юу гэж бодож байна?  
А. Том далбагар навч дэвсэж өнгийн цэцэг тавьсан юм шиг харагддаг  
Б. Нуурын эрэг орчмын гүехэн усанд ургадаг учраас  
В. Тодорхой хугацаанд дэлбээгээ нээж, хумьдаг болохоор  
Г. Байгаль дэлхийн өвөрмөц сонин бүтээл

Асуулт	Хангалтгүй	Дунд зэрэг 5 оноо	Хангалттай 10 оноо
1. Эхийн сэдвийг тодохойлох	А, Г гэж хамааралгүй хариулсан бол 0 оноо	Б. Цэцэгт нуурын тухай гэсэн бол 1 оноо	В Байгалийн сонин үзэгдлийн тухай гэсэн бол 2 оноо
2. Цэцэгс хаана ургадгийг ойлгосон эсэх	А, Б гэж ерөнхий хариулж байгаа бол 0 оноо	В Нуурын эргийн гүехэн устай хэсэг гэж ойлгож байгаа бол 1 оноо	Г. Гүехэн усны ёроолоос ургаж дээш гарч ирснийг ойлгосон бол 2 оноо
3. Эхэд өгүүлэгдэж байгаа хугацааг тодорхой ойлгосон эсэх	А, Г гэж буруу хариулсан бол 0 оноо	Б Үзүүр уснаас ил гарахад нээх гэж ерөнхий нэгийг хариулсан бол 1 оноо	В. Өглөө нээж, орой хумих гэж бүрэн хаиулж байвал 2 оноо
4. Гадаад үгийг уншиж чадаж байгаа эсэх	А, В, Г гэж аль нэг буруу хувилбарыг сонгосон, аль нэг үгийг зөв бичсэн, зөв хариуг соносон ч үгийг бичээгүй бол 0 оноо	Сонгосон хариулт буруу ч Рэнчинлхүмбэ, км, метр гэх үгсээс 2-ыг бичсэн бол 1 оноо	Б.3 гэж сонгоод Рэнчинлхүмбэ, км, метр гэх үгсийг бичсэн бол 2 оноо
5. Эхийн хэсгүүдийн уялдаа холбоог тодорхойлж чадаж байгаа эсэх	Б, В гэж хамааралгүй хариулсан бол 0 оноо	Г. Байгаль дэлхийн өвөрмөц сонин бүтээл гэж ерөнхий дүгнэлтийг сонгосон бол 1 оноо	А. Том далбагар навч дэвсэж өнгийн цэцэг тавьсан юм шиг харагддаг гэж шалтгааныг олж чадсан бол 2 оноо

## ХОЁР. БИЧИХ ЧАДВАР

7 дугаар ангийн сургалтын хөтөлбөрт дармал, бичмэл эхийг уншиж сурахаас гадна галигаас үндэсний бичигт зөв бичих, урт, хос эгшигтэй үгийг зөв бичих, холбох эгшгийн дүрмийг таньж үйл үгийг зөв хувилган бичиж сурсан байх зорилт байгаа. Үсэг үеийг сайтар нүдэлж хичээнгүй бичиж сурах нь 6-р ангийн гол зорилт бол 7-р ангид урт, хос эгшигтэй үг, галиглан бичсэн өгүүлбэр, бичил эхийг зөв бичих, 8-р ангид өгүүлбэр, эхийг галиг болон кириллээс үндэсний бичгээр бичих, 9-р ангид эхийг кириллээс үндэсний бичигт бичих чадвар эзэмших ёстой.

Харин үндэсний бичгийн бичих чадварыг “Сурагч дармал ба бичмэл эхийг хичээнгүй бичиж чадна”, “Сурагч дармал ба бичмэл эхээс урт, хос эгшигтэй үг ба цагаар төгсгөх нөхцөлтэй үйл үгсийг ялган хичээнгүй бичиж чадна” гэсэн шалгуурыг хэр хангаж байгааг мэдэхийн тулд үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлэх, ингэхдээ урт хос эгшигтэй үгийг ялгах, үйл үгийн төгсгөлийг нөхөж бичих зэрэг даалгавар өгнө.

Даалгаврын зорилго: Үндэсний бичгийн дармал эхийг хичээнгүй бичих, урт, хос эгшгийн тухай мэдлэг бататгах.

1. Зүйр үгийг уншаад, хичээнгүй хуулж бичээрэй.
2. Урт, хос эгшигтэй үгсийг ялган тэмдэглэж, урт эгшгийг тэмдэглэх ямар аргууд байна вэ? Бүлэглээрэй.

1. **Суралцахуйн зорилтын чадварыг үнэлэх**  
 2. **Суралцахуйн зорилтын чадварыг үнэлэх**  
 3. **Суралцахуйн зорилтын чадварыг үнэлэх**  
 4. **Суралцахуйн зорилтын чадварыг үнэлэх**  
 5. **Суралцахуйн зорилтын чадварыг үнэлэх**  
 6. **Суралцахуйн зорилтын чадварыг үнэлэх**  
 7. **Суралцахуйн зорилтын чадварыг үнэлэх**  
 8. **Суралцахуйн зорилтын чадварыг үнэлэх**  
 9. **Суралцахуйн зорилтын чадварыг үнэлэх**  
 10. **Суралцахуйн зорилтын чадварыг үнэлэх**

Урт эгшигтэй үг 16 (тийн ялгалын нөхцөлтэй үгсийг оруулан давхардсан тоогоор)

Хос эгшигтэй үг 8 (давхардсан тоогоор)

Богино эгшигтэй үг 18 (давхардсан тоогоор)

Даалгавар хэдий бага боловч сурагч даалгаврыг гүйцэтгэх явцдаа тодорхой хугацааг зарцуулж гурав ба түүнээс олон удаа уншихаас гадна, мэдлэгээ сэргээн санаж, давтаж байх эерэг талуудыг тооцох юм.

Сурагчийн гүйцэтгэлийг суралцахуйн үр дүн, үнэлгээний шалгуур, гүйцэтгэлийн түвшнийг баримталж дүгнэх нь зөв шударга бөгөөд, ил тод байна.

Х ангийн “Сонгодог бичгийн зохиол 2” гэсэн нэгж хичээлийг дараах байдлаар үнэлж болох юм. Гүйцэтгэлийн хүрэх түвшнийг Блумын таксономийн танин мэдэхүйн түвшин, хөтөлбөрийн үнэлгээний шалгуур, агуулгын багтаамж зэрэгт тулгуурлан хийсэн учраас блюпринт зохиоход дөхөм юм.

Блюпринт хийхдээ:  
 Танин мэдэхүйн түвшнүүдээр даалгаврынхаа тоог тогтооно. Өөрөөр хэлбэл үнэлэх төсөл зохионо. Ямар хичээлийн, хэддүгээр ангид, ямар төрлийн, юуны шалгалтыг, хэзээ, ямар хэлбэрээр, юунд тулгуурлан авсан нь тодорхой байна. Үнэлгээний хүрэх түвшин, хичээлийн агуулга, сурах бичгийн агуулга, сурагч бие даан уншсан чадвар, мэдлэг ойлголт, тайлан тайлбарлах чадвар зэргээс шалтгаалан асуулт даалгавраа хүнд хөнгөнийг үндэслэлтэй сонгож боловсруулна.

Нэгж хичээл	Сонгодог бичгийн зохиол 2									
Шалгалтын төрөл	Нэгж хичээлийн үнэлгээ									
Анги	Х анги									
Хугацаа	40 минут									
Шалгалтын хэлбэр	тест								Огноо .....	
Таксономи /Блум/	Сэргээн санах, ойлгох I		Хэрэглэх II		Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх III		Үнэлэх, бүтээх IV		Нийт	
	д.тоо	оноо	д.тоо	оноо	д.тоо	оноо	д.тоо	оноо	д.тоо	оноо
Тоо тоолол	2	1	3	2	3	2	2	3	10	20
Түвшний эзлэх хувь	20%		30%		30%		20%		100%	20

Жишээ нь: Боловсруулсан блюпринтийхээ дагуу 40 минутад 20 онооны 10 тесттэй үнэлгэний даалгавар боловсруулна. Ингэхдээ Хүснэгт 3-т тохируулсан суралцахуйн зорилтын чадваруудыг үнэлэхэд чиглэсэн байна.

- Сурах бичиг дэх дармал, бичмэл, хорголжин бар, хулсан үзгийн тигээр бичсэн бичвэрийг уншиж ойлгодог
- Зохиолоос түүхэн болон хуучирсан үг хэллэгийг олж, утгыг нь тайлбарладаг.

- Сурах бичгийн хүрээнд уншсан зохиолын үгийн санг судалж онцлогийг нь тайлбарладаг.
- Уншсан зохиолд байгаа түүхэн ба орчин цагийн бүтээврүүдийн хэл зүйн онцлогийг тайлбарладаг
- Сургаалын зохиолын үгсийг бүлэглэх, ангилах, төрөлжүүлэх аргаар судалж, түүхэн болон хуучирсан үг хэллэгээр тайлбар толь хөтөлдөг
- Кириллээс үндэсний бичигт хөрвүүлж хичээнгүй тигээр цэвэр нямбай бичдэг.
- Сурах бичгийн хүрээний идэвхтэй хэрэглээ бүхий үгийн үндэс залгаврыг холбох эгшгийн дүрмээр зөв бичдэг гэсэн шалгууруудыг барьж үнэлэхдээ мөн танин мэдэхүйн түвшнээ баримтална.

### Тест буюу сонгох даалгавар нь

Тест даалгавар нь заавар, асуулт даалгавар, зөв хариулт гэсэн гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Заавар нь шалгуулагч юу хийх, хэрхэн гүйцэтгэх, хаана ямар бичиглэл, тэмдэглэгээ хийх, ямар хугацаанд гүйцэтгэх зэргийг, асуулт даалгавар нь сургалтын агуулгыг, зөв хариулт нь нэг утгатай зөв хариултыг багтаан үзнэ.

### I. Сэргээн санах, ойлгох түвшинд

Аль нь орчин цагийн монгол хэлний “-на4” залгавар бүтээвэртэй утга ижил вэ?

a	b	c	d
- өөл	- нол	- лт	- Ра

гэх зэргээр сурагч мэдэж байх шаардлагатай суурь ойлголтуудыг шалгана. Төдийлөн хэрэглэж дадаагүй байж болно. Танин мэдэхүйн доод түвшний даалгавар учир бүх сурагч жигд хийж гүйцэтгэл сайн гарах магдлалтай учир өндөр оноогоор үнэлэхгүй.

### II. Хэрэглэх түвшинд

Бусдаасаа ялгаатай залгавар бүтээврийг олоорй.

a	b	c	D
- lda	- ldo	- lca	- lja

гэх зэргээр сурагч уншиж ойлгоод, үйлээс нэр үг үүсгэх –лт дагаврыг үйл үгийн –лд, -лц, -лз зэргээс ялгаж чадаж байгаа эсэхийг харах боломжтой. Үүний тулд сурагч нүдлэн тогтоосон байх албагүй ч үгэнд залгаж уншиж бичиж үзээд олох юм. Хэрэглэж чадаж байгаа эсэхийг шалгах учир оноожуулалт мэдлэг, ойлголтын даалгавраас багахан өндөр байж болох боловч мөн л танин мэдэхүйн доод түвшний даалгавар учир хэт өндөр оноогоор үнэлэхгүй.

### III. Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх түвшинд

Аль хэсэгт “— eedoа, - kdoа ” илүү тохиромжтой вэ?

a	b	c	d
bfj)T fejiiT	Moiko Soik	Forgo Bika	Jogowa Morila

гэх зэргээр сурагч уншиж ойлгоод тохирох, үл тохирохыг олохын тулд бүх үгэнд залгаж үзэн морил-, зоогло- гэсэн үгэнд залгахад илүү тохиромжтой гэж сонгоно. Бүгд үйл үгс учир бүгдээр тохирч болох шиг санагдана Гэвч нүд-, сөх- гэсэн үгсэд тохирох боловч хүндэтгэлийн утга нь саарна.

Алжаа-, базаа- гэсэн үгс мөн утга саарч хүнийг алжааж ядар гэсэн утгаар хэрэглэж үл болно. Булги-, урга- үгсийн тухайд хүний үгийг сонсож ёсчлон дагахгүй адгуус, ургамалд хэрэглэх үгс учир нийлэмжийн хувьд хамгийн муу гэдгийг сурагч эргэцүүлж бодох хүндэвтэр даалгавар болно.

Зөв хариултыг олохын тулд сурагч багагүй ажиллах танин мэдэхүйн дээд түвшний даалгавар учир өндөр оноогоор үнэлж болно. Гэвч шалгалтын эцсийн дүнд мэдэгдэхүйц өндөр оноогоор үнэлж бас болохгүй.

**IV. Үнэлэх, бүтээх түвшинд**

Залгавруудыг жишээтэй нь зөв харгалзуулна уу?

a	b	c	d	
· ·	·	· ·	· ·	1 Эх хэлээ сур
Lo)T	ra	Bo)T	Yogva	2 Ах дүүтэйгээ уулз
loKt		K)T	Yokla	3 Авъя гэвэл өг
				4 Эхрийг сурахаар бэрхийг сур

гэх зэргээр сурагч даалгаврыг гүйцэтгэхдээ залгавруудыг уншиж, жишээтэй харгалзуулахдаа бүтээврүүд ямар утгаар хэрэглэгдэж байгааг шинжин мэдэх, тохируулах түвшний даалгавар учир сурагч сайн гүйцэтгэх нь тухайн ойлголтыг сайн эзэмшсэн байгааг илтгэнэ. Мөн будлиж алдаа гарах магадлал ч маш өндөр. Энэ мэтчилэн блюпринтийн дагуу 20 тестээ агуулга, танин мэдэхүйн түвшинд тохируулан зохиож үр дүнг нь тооцно.

**Задгай даалгавар нь**

Энэ хэлбэрийн даалгаварт сурагч чөлөөтэй, дэлгэрэнгүй хариулдаг тул танин мэдэхүйн дээд түвшний чадварыг үнэлэхэд тохиромжтой. Сурагч хичээлээр олж авсан мэдлэг, чадвараа ашиглан асуудал шийдвэрлэх, мэдээллийг шүүх, үнэлгээ өгөх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, өөрийн санааг бусдад ойлгуулах, тайлбарлах зэрэг чадвар шалгаж байхаар даалгавар боловсруулна. Задгай даалгаврын хариултын хувилбар, үнэлгээний шалгуураар суралцагчийн ялгаатай байдалд дүн шинжилгээ хийх боломжийг олгодог. Тухайн асуултад нэгээс илүү хүлээн зөвшөөрөгдсөн хариулттай байх бөгөөд нэгээс олон аргаар бодолт хийх боломж өгдөг. Энэ нь багшийн хувьд сурагчаа таних, цаашид хөгжүүлэх боломжийг харах ач холбогдолтой.

Задгай даалгаврууд ерөнхий мэдээлэл өгөх байдлаар эхэлж болох ч хэт их, нуршсан байх нь сурагч залхаж тухайн даалгаврыг гүйцэтгэх сонирхолгүй болгох талтай байдгийг анхаарах нь зөв. Даалгавруудаа алхамчилсан бүтэцтэй буюу хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн, бүрэн дунд боловсролын хэмжээнд 5-10 алхамтай, алхам бүр өөр өөр мэдлэг чадвар шалгахаар боловсруулна.

Нэгж хичээл	Сонгодог бичгийн зохиол 2									
Шалгалтын төрөл	Нэгж хичээлийн үнэлгээ									
Анги	Х анги									
Хугацаа	40 минут									
Шалгалтын хэлбэр	задгай									Огноо .....
Таксономи /Блум/	Сэргээн санах, ойлгох <b>I</b>		Хэрэглэх <b>II</b>		Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх <b>III</b>		Үнэлэх, бүтээх <b>IV</b>		Нийт	
	д.тоо	оноо	д.тоо	оноо	д.тоо	оноо	д.тоо	оноо	д.тоо	оноо
Тоо тоолол, олон тооны дагавар	1	1	2	1	1	3	1	4	5	10
Түвшний эзлэх хувь	20%		40%		20%		20%		100%	10

Бичих чадварт суурилсан задгай хэлбэрийн даалгаврын блюпринтийг унших чадварт суурилсан даалгавраас цөөн тоогоор боловсруулна. Даалгаврыг гүйцэтгэх хугацаа, багтаамж, хэмжээ зэргээс шалтгаалж оноо ч мөн эрс ялгаатай байж болно. Сурагчийг тестээр шалгахад тодорхой хүрээнд өмнө нь бэлдсэн хариултуудын аль нэгийг нь сонгодог хаалттай байдаг бол задгай даалгаврын хариулт хэдэн ч хувилбар байж болно гэдгийг урьдаас тооцож бэлдэх хэрэгтэй. Хариултын найруулга ямар байхаас үл шалтгаалан гол чадвараа ямар түвшинд эзэмшсэн байна гэдгийг бодитоор үнэлэхэд шалгуурууд тус болно. Жишээ нь, задгай даалгаврын блюпринтийн хүрээнд:

**Сэргээн санах ойлгох түвшинд**

“HOLA Kline BO CoiK, YeBbISO Kiroyo KiedO Kline BO CoiK, frKbISO Degegeyo” өгүүлбэрийг уншиж ойлгоод, түүхэн бүтээврүүдийг ялган тайлбарлаарай гэх зэргээр “Уншсан зохиолд байгаа түүхэн ба орчин цагийн бүтээврүүдийн хэл зүйн онцлогийг тайлбарладаг” гэсэн шалгуураар шалгана. Хөтөлбөр, шалгуураас давсан агуулгаар сурагчийг шалгахгүй.

Хүснэгт 10

Үнэлгээний шалгуур / оноо	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Уншсан зохиолд байгаа түүхэн ба орчин цагийн бүтээврүүдийн хэл зүйн онцлогийг тайлбарладаг	Сургаалын зохиолоос түүхэн бүтээврийн хэл зүйн онцлогийг таньж тайлбарладаг	Сургаалын зохиолоос түүхэн бүтээврийн хэлбэрийг орчин цагийн хэлбэртэй нь тохируулан тайлбарладаг	Түүхэн ба орчин цагийн бүтээврүүдийн хэлбэрийг харьцуулан тайлбарладаг	Сургаалийн зохиолын үгийн сан, хэл зүйн онцлог шинжийг тайлбарладаг.
ОНОО	0.25	0.5	0.75	1

Оноожуулахад блюпринтийн дагуу сэргээн санах, ойлгох түвшинд 1 даалгавар 1 оноотой байгаа учир 1 оноогоор үнэлнэ. Шалгуурын дагуу хийж чадсан бол 1 оноо, чадаагүй бол 0 оноо. Гүйцэтгэлийн 4 түвшин ч мөн адил ямар нэгэн аргаар хийж чадсан л бол шалгуурыг хангасан гэж үзэж байна. 1 оноогоо нарийн ялгамжтай задалж дүгнэсэн ч болно. Үүний тулд багш уншуулж аман хэлбэрээр шалгаж байх явцад хэрэглэх нь илү тохиромжтой. Эс бөгөөс дэвтэрт гүйцэтгэж өгсөн даалгавраас үелж, нүдэлж, шууд уншиж байгаа эсэх нь тодорхойгүй, уншиж чадсан эсэх нь л харагдана.

**Үнэлэх, бүтээх түвшинд**

“bIT Bikt BIKSO Geeca JI fileyO Seokuk Bikt BIKSO folea I fileyO” өгүүлбэрийг уншиж ойлгоод, түүхэн бүтээврүүдийг ялгаж, утга дүйх орчин цагийн бүтээврээр солин найруулаарай гэх зэргээр даалгавар бэлдсэн бол “Сурах бичгийн хүрээнд уншсан зохиолын үгийн санг судалж онцлогийг нь тайлбарладаг”, “Уншсан зохиолд байгаа түүхэн ба орчин цагийн бүтээврүүдийн хэл зүйн онцлогийг тайлбарладаг” гэсэн үнэлгээний шалгуураар шалгана гэж ойлоно. Үнэлгээ нь мөн адил сургалтын нэг процесс болохоор танил бус үг өгүүлбэр сонгож даалгаврыг хүндрүүлж болохгүй.

Хүснэгт 11

Үнэлгээний шалгуур / оноо	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Сурах бичгийн хүрээнд уншсан зохиолын үгийн санг судалж онцлогийг нь тайлбарладаг.	Сургаалын зохиолоос түүхэн, хуучирсан үг хэллэгийг олж, таньж тайлбарладаг.	Сургаалын зохиолоос түүхэн, хуучирсан үг хэллэгийн утгыг хам сэдвийн хүрээнд таамаглан тайлбарладаг.	Сургаалын зохиолын үгийн санг судалж өвөрмөц, уламжлалт бичлэгтэй үгсийг тольчлон тайлбарладаг	Сургаалын зохиолын үгийн сангийн онцлогийг тодорхойлж тайлбарладаг.
ОНОО				

Уншсан зохиолд байгаа түүхэн ба орчин цагийн бүтээврүүдийн хэл зүйн онцлогийг тайлбарладаг	Сургаалын зохиолоос түүхэн бүтээврийн хэл зүйн онцлогийг таньж тайлбарладаг	Сургаалын зохиолоос түүхэн бүтээврийн хэлбэрийг орчин цагийн хэлбэртэй нь тохируулан тайлбарладаг	Түүхэн ба орчин цагийн бүтээврүүдийн хэлбэрийг харьцуулан тайлбарладаг	Сургаалийн зохиолын үгийн сан, хэл зүйн онцлог шинжийг тайлбарладаг.
ОНОО	1	2	3	4

Дээрх даалгаварт тохирсон оноог одоо яаж өгөх талаар асуудал урган гарч байна. Тэгвэл задгай даалгаврын блюпринтээ ахин харвал үнэлэх, бүтээх түвшний 1 даалгавар 4 оноотой. Иймд энэ даалгаврыг 4 оноонд хувааж үзнэ. Өгөгдлийг уншиж ойлгох, түүхэн бүтээврийг олох, өөр бүтээврээр солин найруулах гэсэн 3 алхам хийх тул оноогоо хэрхэн дүгнэхээ тооцож тодорхой, нарийн задалж оноожуулна. Энэ нь эргээд үр дүнгээ тооцоход суурь болно.

Сонгож авсан нэгж хичээлийнхээ бусад шалгуурыг мөн адил “Сурах бичиг дэх дармал, бичмэл, хорголжин бар, хулсан үзгийн тигээр бичсэн бичвэрийг уншиж ойлгодог”, “Зохиолоос түүхэн болон хуучирсан үг хэллэгийг олж, утгыг нь тайлбарладаг”, “Сургаалын зохиолын үгсийг бүлэглэх, ангилах, төрөлжүүлэх аргаар судалж, түүхэн болон хуучирсан үг хэллэгээр тайлбар толь хөтөлдөг”, “Кириллээс үндэсний бичигт хөрвүүлж хичээнгүй тигээр цэвэр нямбай бичдэг” гэсэн шалгуураар мөн адил шалгаж, нэгж хичээлийн агуулгад багтсан суралцахуйн зорилт бүрийг шалгах шалгуурыг орхигдуулахгүй байх нь нэн чухал. Эцэслэн үнэлсэн мэдээллээс ямар сурагч, агуулгаа бүрэн эзэмшсэн, ямар чадвартай болсон, ямар сурагч хоцрогдолтой байгаа зэргийг мэдэж дараагийн нэгж хичээлийг ямар агуулгын хүрээнд боловсруулах хэнд нь нэмэлт даалгавар өгч бүр илүү чадваржуулах, хэнд нь илүү чадваржуулах даалгавар өгөх, цаашид юунд анхаарах зэргийг төлөвлөнө.



## Дөрөв. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал

Хичээлийн жилийн эхэнд (1) сурагчид төгссөн ангийнхаа агуулгыг хэр зэрэг мэдэж байгааг, (2) тухайн ангийн агуулгын хүрээнд ямар ойлголт, мэдлэг олж авсан, (3) унших бичих, ярих, сонсох, задлан шинжлэх гм сурах арга барил хэр зэрэг эзэмшсэн гэх зэргийг урьдчилан оношилдог. Гэтэл ихэнх тохиолдолд сурагчдын хэдэн хувь А, хэдэн хувь В, хэдэн хувь С, хэдэн хувь D, хэдэн хувь F үнэлгээтэй шалгагдсаныг л гаргаад дээрх оношлох зорилготой гол асуудлаа орхигдуулдаг. Мөн шалгалтын үр дүнд шинжилгээ хийж, даалгаврыг яаж гүйцэтгэж байгаа, амьдралаас олж авсан ойлголт нь хэр бодитой, зөв байгаа, ямар сурах арга барилыг түлхүү эзэмшсэн байгаа гэх зэргээр суралцахуйд зайлшгүй шаардлагатай чухал асуудлаа олж илрүүлэх нь чухал юм. Ямар агуулгыг сурагчид бүрэн дүүрэн эзэмшсэн, ямар агуулгыг дутуу хагас, ямыг нь буруу зөрүү ойлгосон юуг огт мэдэхгүй байгаа гэх зэргээр нарийн оношилж илрүүлэх нь суралцахуйг бодитой дэмжих арга замаа тодорхойлоход чухал байх юм.

Харин үр дүнгийн үнэлгээний дүн мэдээлэлд үндэслэн сурагчдын мэдлэг, чадварын түвшний ялгаатай байдлыг зөв гаргаж түүндээ үндэслэн тус бүрээр ялгаатай даалгавар өгч ажиллуулах замаар хүүхэд бүрийн түвшнийг нь ахиулах боломжтой. Ингэж ажиллахын тулд л суралцахуйн үр дүн, үнэлгээний шалгуураа маш сайн ойлгосны үндсэн дээр шалгалтын агуулгаа зөв боловсруулах, үнэлгээг зөв хийх юм.

Хичээлийн төгсгөлд үнэлгээ хийж үр дүнг нь тооцохдоо нэг хүрэх цэгт бүрмөсөн хүрчихлээ гэж тооцож ерөөс болохгүй. Ойрын зорилгоо хангаж, цааш явах вэ гэдгээ ямагт тооцоолно. Цаашдаа ч мөн Х ангид эзэмшсэн байх дараах суралцахуйн үр дүнгүүдийг хангахаар ажиллана. Бидний сонгож авсан нэгжид тохирч байх шалгуурууд нь мөн үр дүнг хангахаар чиглэж байгаа.

- ✓ Сурагч сурах бичигт байгаа ялгаатай тигээр бичсэн зохиол бүтээлийг уншиж, ойлгодог болно.

- ✓ Сурагч сурах бичиг дэх түүхэн, хуучирсан үгийн утгыг тайлбарлаж чаддаг болсон байна.
- ✓ Сурагч сурах бичгийн хүрээнд уншсан зохиол дахь түүхэн, хуучирсан үг хэллэгийн үгийн сан, хэл зүйн онцлог шинжийг тайлбарлаж чаддаг болсон байна.
- ✓ Сурагч үндэсний бичиг ашиглах, толь хөтлөх арга барил эзэмшсэн байна.
- ✓ Сурагч сурах бичгийн хүрээний идэвхтэй хэрэглээ бүхий үгсийг алдаагүй, зөв, хичээнгүй бичиж чаддаг болсон байна.

Харин үр дүнд хүрч чадаж байгаа эсэхээ сурагчийн хариултын мэдээллээс харна. Жишээ нь: 31 сурагчтай ангиас “Сонгодог бичгийн зохиол 2” нэгжээр задгай хэлбэрийн даалгавраар үнэлгээний шалгалт авч хариултын мэдээлэл нь доорх Хүснэгт 9 “блюпринтийн хэрэглэх түвшинд боловсруулсан даалгаврын гүйцэтгэл хангалтгүй” байдлаар гарсан бол цаашдын сургалтын үйл ажиллагаа, хичээл төлөвлөлтөдөө “Сурах бичгийн хүрээнд уншсан зохиолын үгийн санг судалж онцлогийг нь тайлбарладаг” гэсэн үнэлгээний шалгуурыг хангахад илүү анхаарч, дараагийн нэгж хичээлийн даалгавар ажлын хуудас бүрд уншуулж бичүүлэх, нүдлэн тогтоох, сургалтын идэвхтэй үйлүүдийг эрчимжүүлнэ. Мөн олон тооны дагаврыг зөв хэрэглэдэг болгох дасгал даалгавруудыг монгол хэлний хичээлтэй нь холбон зааж болно.

Хүснэгт 12

Үнэлгээний шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин				Гүйцэтгэлийн хувь
	I түвшнийг хангасан сурагч	II түвшнийг хангасан сурагч	III түвшнийг хангасан сурагч	IV түвшнийг хангасан сурагч	
Сэргээн санах, ойлгох	3	6	14	8	77.4%
Хэрэглэх 1	13	9	7	2	57.4%
Хэрэглэх 2	5	7	12	7	73.5%
Задлан шинжилж, нэгтгэн дүгнэх	8	14	3	6	64.5%
Үнэлэх, бүтээх		11	15	5	76.1%
Нийт	29	47	51	28	69.8%

Хэрэглэх 1 даалгавар байрлаж байгаа хэвтээ шугамыг харахад I түвшинд байгаа сурагчдын тоо хэт олон байгаа нь гүйцэтгэлийн хувь буурахад нөлөөлж байна. Харин босоо шугамын нэгтгэлийг харвал II, III түвшинд байгаа сурагчид олон байгаа нь сурагчдын чадвар шалгуурыг IV түвшинд хангахад арай дутмаг байгаа нь юунд байна вэ гэдгийг дүгнэх боломжийг олгоно. Зүй нь бол ангийн 31 сурагчаас IV түвшнийг хангаж байгаа сурагчдын тоо их, I, II түвшний сурагчдын тоо бага байх тусам сургалт амжилттай явж байна гэж ойлгох нь зүйтэй.

Үнэлгээний үр дүнг багшлахуйд ашиглахад:

**1. Бэлтгэл хангах**

(Шалгалт, судалгааны гүйцэтгэлд шинжилгээ хийх, хамгийн их, бага гүйцэтгэлтэй даалгаврыг ялгах, тухайн даалгаврыг гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг чадварыг хөтөлбөр сурах бичгээс ялгах, цуглуулах)

**2. Боловсруулах**

(Сонгосон сэдвийн хүрээнд сурагчийн эзэмших мэдлэг, чадварыг тодорхойлох, танилцуулах, арга зүйн хувьд анхаарах зүйлсийг тодорхойлох, явцын үнэлгээний тохиромжтой хэлбэрийг сонгох)

**3. Туршин заах**

**4. Сайжруулах**

(Хичээлийн хэлэлцүүлгийн тэмдэглэлд үндэслэн хичээлийн агуулга, арга зүйг сайжруулах)

## 5. Туршлага хуваалцах

(Хичээлийн арга зүй, шинэ санааг цахимаар хуваалцах, мэргэжлийн багш нарт сургалт зохион байгуулах, нээлттэй хичээл заах, илтгэл хэлэлцүүлэх) зэргээр багшлахуй болон суралцахуйд дэмжлэг үзүүлэхээс гадна сургалтын хөтөлбөр, сурах бичгийг сайжруулахад санал өгөх, багаараа судалгаа хийх, хамтарч хөгжих олон боломжтой.





**ЕБС-ийн Монгол бичиг хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:**

Т.Отгон-Эрдэнэ                      Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн

**Хөндлөнгийн шинжээч:**

Ө.Цэндсүрэн                      Монгол улсын гавьяат багш

**Техникийн редактор:**

М.Болдсайхан                      Боловсролын үнэлгээний төвийн хэлтсийн дарга

Ш.Сувдмаа                      Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

**Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:**

С.Мөнхмаа                      Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр

**Цаасны хэмжээ:**                      А4

**Хэвлэлийн хуудас:**                      4.5 х.х



*Дэлгэрэнгүй мэдээллийг:*

[www.eec.mn](http://www.eec.mn)



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,  
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,  
Утас/Факс: 976-11 7011- 8486  
И-майл: [info@eec.mn](mailto:info@eec.mn) Вэб: [www.eec.mn](http://www.eec.mn)